

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лүндэг	Дугаар	L167
Оршин суугаа аймаг	Сэлэнгэ	Оршин суугаа сум	Шаамар
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Эрдэнэ вангийн хүрээ	Сүм хийдийн дугаар	СЭЦН 022
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 24	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Эрдэнэ вангийн хүрээ

Асуулт:-Тус сумын нутагт байсан Хайлаастын дуган болон **Эрдэнэ вангийн** хүрээний талаар мэдэх зүйлээ ярьж өгнө үү?

Хариулт:-Хайлаастын дуган гэж энэ дээр Үржихийн ард энэ дээр төмөр замын **точик байнаа** даа, тэрний урд хүрээн дор байсан юм.

Асуулт:-Хогийн **хонхорыг** хэлээд байгаа юмуу?

Хариулт:-Тийм. Яг тэнд чинь байсан юм, Хайлаастын дуган. Улиастын дуган гэж яг манай энэ баруун талын **Манчиг** голын цаад талын хэсэгт цагаан дээр Улиастын дуган гэж байсан юм.

Асуулт:-Бас өөр үү?

Хариулт:-Тийм. Хоёр дуган байсан юм. Хайлааст, Улиаст гэж.

Асуулт:-Хайлаастын дуган хэд орчим ламтай дуган байсан юм бол?

Хариулт:-Тэр үед чинь 2 л хуваагдаж байсан юм даа, Хайлааст, Улиаст гэж. .. айлууд, Хайлаастын айлууд гээд. 10 хүрэхгүй лам нартай байсан юм. Балдан гэлэн гэж тэр **дацангийн** их лам нь.

Асуулт:-Хамба лам нь байсан юмуу?

Хариулт:-Хамба ч бишээ, зүгээр нэг лам нь. Улаан гэлэн гэж бас байсан юм.

Асуулт:-Юугаар барьсан байсан юм бол?

Хариулт:-Дүнзэн байшин байсан юм. Их шар будгаар будчихсан дүнзэн байшин байсан юм.Энд чинь угаасаа дүнзэн байшин байсан юм. Эндхийн лам нарыг би сайн мэдэхгүй байна. Эндхийн хурал дээр ирж байгаагүй, Хайлааст, Улиастын дуган гэж байсан.

Асуулт:-Хайлаастын дуганыг хэд орчим оны үед анх үүсгэж байгуулсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тэрнийг би мэдэхгүй юм, бага байсан. Хурал ном хурж байхад 10 хэдтэй байсан. Тэрнээс нэлээн хэдэн жилийн өмнө байсан юм даа.

Асуулт:-Та одоо хэдтэй билээ

Хариулт:-Би 93-тай.

Асуулт:-Хайлаастын дуганы лам хуврагууд ямар уул овоогоо тахидаг байсан юм бол?

Хариулт:-Хазгар Янжив гэж унзад нь байсан. Балдан гэлэн гэж лам байсан, Улаан гэлэн гэж лам нь байсан.

Сахил Самдан, Буурал гэлэн гэж хүн байсан. Тэр дуганыг бүр хариуцан сууж байсан. Сахил бурхан, хурал ном хурахад ч юмуу, янз бүрийн юм хийдэг тийм хүн байсан юм. Балдирын **Дэлэгдорж** гэж тэр дуганы нярав гэх үү дээ.

Асуулт:-Аж ахуйн ажлыг нь хариуцсан хүн юмуу?

Хариулт:-Тийм. Данс **тооцоогий** нь, хурал ном хурахад юм өгнө шүү дээ, тэрнийг бичиж авч, дансалж барьдаг нярав нь байсан юм.

Асуулт:-Балдирын хийдийн...

Хариулт:-Тийм.

Асуулт:-Аль уулыг тахидаг байсан гэнээ?

Хариулт:-Урд Үржиг овоо гэдгийг манай энд их тахиж байсан. Одоо энэ хүн тавьдаг газар **байнаа** даа. Алтан Өлгий гээд. Тэрний хойд дээр нэг шовгор уул байгаа биз дээ.

Асуулт:-**Антенн** шиг юм босгочихсон уу?

Хариулт:-Тийм. 3, 4 жилийн өмнө би энэ Лам сүмийн нас барчихдаг хэн билээ дээ, тэрэнд хэлж байж, овоо, чулуугаар... **Чүлтэмцэнд**. Тэрэнд хэлж овоог босгуулсан.

Асуулт:-Одоо **тэрэн** дээр овоотой болсон уу?

Хариулт:-Овоотой болсон. Сангийн бойпор гэж 1 тн гаруй хайргаар хийсэн сангийн бойпор байсан юм. Тэрнийг дээр үед бүр зүүн тийшээ бөмбөрүүлээд газар буулгачихсан байсан юм. Тэрнийг нь хүртэл авчирч тавиулаад, одоо нэг чулуун овоотой байж байгаа. Томоо дээр үед яаж ч хийсэн юм байгаа юм, нэг хайрган чулуугаар нэг их том бөөрөнхий.

Асуулт:-Хайлаастын хийдийн гол шүтээн нь ямар бурхан байсан бол?

Хариулт:-Гол шүтдэг бурхан **Дамдинчойжоо** гэж байв уу? тэр гол шүтдэг бурхан чинь бүр их том даавуун дээр. Ингээд суйлаад бөөрөнхийлөөд аваад явдаг...

Асуулт:-Зурмал бурхан байсан юм уу?

Хариулт:-Тийм. Тэрнийг бол энэ нутгийнхан хаврын эхэн сард жилд нэг удаа Хайлаастаа тойруулж мөргөдөг.

Асуулт:-Гороо хийдэг байсан юмуу?

Хариулт:-Тийм. Судар номыг нь моринд аччихсан, цагаан морь хөллөчихсөн, нэг их улаан зангиа хүзүүнээс нь уячихсан тийм морь.

Асуулт:-Морин дээр хоёр хүн хоёр талаас нь барих уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Үгүй. **Тэрэн** дээр дандаа Жадамба, **Сандуй** зэрэг ийм том том судрууд уншиж явдаг. Тэрнийг ачдаг ачаа. 100 кг-ийн хэрээтэй тийм номууд нэг моринд аччихсан. Нэг хүн тэр шүтээнийг урдаа морин дээрээ ингээд явж байдаг. Ингээд айлуудаар орно. Тэр Үржиг дээрээс буугаад, Банзрагчийн хөндий буугаад, **Ханчийн** булан гэж байсан юм. **Ханчийн** булангийн эгц дээшээ, тэрний баруун ард байгаа юм. Тэнд манайх байсан юм. Баян Балжирынх, **Дэлэгдоржийнх** эд нар чинь манайхан тэнд байсан юм. Тэнд очиж нэг хонож, тэгээд баруун тийшээ эргээд Бага бүүрэг, Их бүүрэг гээд цаагуур яваад, ингэж тойроод баруун урд **бирвааз** байсан юм. Асуулт:-Сумынхаа төвийн тэрүүгээр үү?

Хариулт:-Үгүй, бүр энэний наагуур, манай энд. Тэгээд ингэж тойроод хүрч ирж дуган дээрээ буудаг.

Асуулт:-Урдуур гарахдаа яаж гардаг байсан юм бэ?

Хариулт:-Урдуур гарахдаа Үржиг овооны Алтан өлгийн баруун талд нэг их нарс ургасан **байнаа** даа, тэгэхэд чинь ганц хоёрхон зулзага байсан юм намайг 10 хэдтэй байхад. Одоо харахад битүү нарс ургасан байгаа. Тэрүүгээр чинь буугаад тэгээд 49-өөр буугаад. 49-р **точик** гэж номонд байна шүү дээ. Тэрүүгээр буугаад. Тэгээд баруун тийшээгээ **өгсч** гараад манайхан байгаа, тэнд очиж хоноглоно.

Асуулт:-Хайлаастын хурал гэж хурж байсан энэ газар хэзээ байхгүй **болчихов?**

Хариулт:-1920 оны үед устсан юм даа. Би мартчихаад байна даа. Социализмын үед баахан бурхан шашин хэрэггүй болоод явчихлаа шүү дээ, тэр маань чухам хэдэн онд **байнав?**

Асуулт:-Ардын хувьсгал гарч байхад энэ дуган байсан юмуу?

Хариулт:-Байсан.

Асуулт:-Тэгвэл 21 оноос хойш юм байна. Тэгвэл 37 оны хэлмэгдүүлэлтийн үеэр үү?

Хариулт:-Тэр л үеэр болов уу даа.

Асуулт:-Лам нарыг нь яасан?

Хариулт:-Лам нар тэгэхэд чинь **Хоринсүрэнгийн** ах Сундуй гэлэн гэж байсан. Энэ дуганд бас ирж хурж байсан, баруун **Эрдэнэ вангийн** хүрээн дээр байсан юм. Сундуй **гэлэн** гэдгийг л бариад явахыг би сайн мэддэг юм.

Асуулт:-Ногоон малгайтнууд л ирээд барьсан уу?

Хариулт:-Тийм. Дотоод яамныхан гэж нэг ногоон малгайтай улсууд байлаа шүү дээ.

Асуулт:-Лам нарыг нь бариад явчихсан, хурал ном нь хаагдаад, дуган сүмийг нь яасан юм бол?

Хариулт:-Дуган сүм нь сүүлдээ чухам яагаад алга болсон юм, хичнээн сайхан дуганыг чинь нураагаад тэгээд алга болсон. Цав манж хийдэг, бас нэг мань хүний суудал шиг ийм юмтай, бас нярав суудаг байшинтай, ийм 3 амбаартай л юм байсан юм. Тэрнээс нэг **их сүм** байгаагүй, гадуураа нэг их хашаа байгаагүй. Энэ талдаа Хүүхдийн овоо гэж нэг овоо байсан. Баруун урд талдаа. Тэрэнд хавар хүүхдүүд бүр Хайлаастын бүх хүүхдүүд, ... бүх хүүхдүүд цуглаж тахидаг байсан, лам хүүхдүүд. Тэгээд ямар наадам хийдэг гэхээр хооронд нь барилдуулна, хооронд нь уралдуулна.

Асуулт:-Явганаар уралдах уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Явганаар уралдана. Элстэйн амны энэ талд гол өөдөө шаасан нэг хошуу байгаа даа, вагон тойроод байгаа. Тэр хошууны чинь тэндээс тэр дуган хүртэл гүйдэг юм.

Асуулт:-Дуган тэр хошуунаасаа хэр зэрэг зайтай байсан юм.

Хариулт:-Нэлээн зүүн мухар өөдөө байсан.

Асуулт:-Цаад мухар луугаа биш юм байна тийм ээ?

Хариулт:-Тийм. Зүүн тийшээгээ. Сонин юм болгож та нар **урдны** юм асуугаад байхаар тэр уралдаанд жил болгон би түрүүлдэг байлаа. Нэмэхийн Улаанхүү гэж нэртэй байсан юм би. Хэдэн чихэр, хэд гурван улаан мөнгө, цагаан мөнгө эд нартай шагнал авчирдаг байлаа. Одооны хурдан морирхуу.

Асуулт:-Ийшээ том том хийдүүд бий шүү дээ, Найрамдлын нутагт байсан?

Хариулт:-Баруун тийшээ чинь том том хийд гэж юу **байхав** дээ, **Эрдэнэ вангийн** хүрээ л байна. Ламын гэгээний хүрээ цаахна талд нь, **Төвхөн хан** уулын урд. Тэнд би очиж байгаагүй, **Эрдэнэ вангийн** хүрээн дээр би сууж байсан.

Асуулт:-Та Улиастайн хурлын талаар хэр мэдэх вэ?

Хариулт:-Тодорхой сайн мэдэхгүй.

Асуулт:-Газар нь олдох уу? суурь нь олдох уу?

Хариулт:-Суурь гэж байхгүй. Бүр эдгэрчихсэн.

Асуулт:-Голынхоо цаана юмуу?

Хариулт:-Минжийн голынхоо цаана, Орхоныхоо наад талд.

Асуулт:-Орхон, Минж хоёрынхоо дунд юмуу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-**Эрдэнэ вангийн** хүрээн дээр та хэдэн настай байхдаа сууж байсан бэ?

Хариулт:-Би гэртээ ах дүү 2 эрэгтэй хүүхэд байсан юм байна, тэр үед. Миний ах Дэндэв гэж байсан, би Улаанхүү. Урд чинь 2 эрэгтэй хүүхэд байхад нэг нь өрхийн тэргүүлэгч гэж хар хүн байдаг ёстой. Нэг нь лам байдаг ёстой байлаа. Би лам болох гэж **Эрдэнэ вангийн** хүрээн дээр очсон.

Асуулт:-**Эрдэнэ вангийн** хүрээ гэдэг маань одоогийн Сэлэнгэ аймгийн ямар сум бэ?

Хариулт:-Цагааннуур сум. Тэнд би 10-аад настай очсон юмуу, яваад гүйгээд байсан юм даг. Тэрнийг би сайн мэдэж байна. Манай ээжийн эгч гэж нэг Тангадын Даваа гэж байсан тэдний нэг охинтой суусан **Дашлхүмбэ** гэж хүн байсан. Тэрэнд лав нэг үнээгээ алаад ачуулаад намайг үхэр тэргэн дээр суулгаад тэр хүрээ өөд явуулж байсан юм даа. Би тэнд очоод хурал номонд суугаа ч үгүй. **Эрдэнэ вангийн** хүрээн дээр чинь 13 аймаг байсан, жижиг аймаг. Содномдаржаа гэдэг аймагт би тэнд данстай байсан юм. Ваанчиг зурхайч гэж Содномдаржаа аймгийн том лам нь байсан. Тэгээд жил гаруй болоод. Би ногоон Гэлэн гэж байсан тэднийд намайг суулгасан юм, би одоо хүртэл мэдээд байдаг юм. Гэрээ санаад сууж байж болдоггүй. Тэгсэн намайг эргэхээр хүн ирсэн. Тэгэхээр нь би ээжийгээ дагаад салдаггүй. **Эрдэнэ вангийн** хүрээний энэ талд урагшаа Гэлэнгүүдийн, цагаан хошуу байгаа. Тэрнийг хүртэл дагаад. Тэгээд аргаа бараад ээж **Дэлэгдорж** гээд түрүүнд би яриад байлаа, тэр

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

чинь Самдан гэлэнгийн гэдэгт бас нэг шавь хүн байсан, тэнд ажиллаж байсан. Хүү маань гэрээ санаад надаас салж өгөхгүй гэсэн. Ингээд ингээд би жил гаруй суугаад **Эрдэнэ вангийн** хүрээнээс гараад дахиж очоогүй.

Асуулт:-Хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-1000 хүрээ биз. 13 аймгийн лам гэдэг чинь ямар их билээ? Цогчэн дуган гэдэг чинь суурь нь байгаа биз дээ. Би очоогүй болсоор олон жил болсон. Та нар явсан юмуу үгүй юмуу?

Асуулт:-Явсан, нэг балгас байна лээ.

Хариулт:-Хоёр уулын хооронд.

Асуулт:-Тийм. Сэлэнгийнхээ зах руу маягтай тийм ээ?

Хариулт:-Тийм. **Урагшаагаа**.

Асуулт:-Ламын гэгээн ямар учиртай байсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй, ганц том ламын л эзэмшсэн дуган сүм байсан. Би **тэрэн** дээр очиж үзээгүй. Баруун тийшээгээ Цагааннуураас хайрцаглаж, баруун, зүүн **хамжааныхан** гэж ярьдаг. Тэр хамжааны бүх айл өрхүүдийн шүтлэгээр буй болсон юмуу, хаашаа юм сүм байгуулсан юм гэнэ лээ.

Цогчэн унзад гэж Лувсан унзад гэж байсан. Их өндөр хүн байсан. Уран сайхны талаар янз бүрийн хоолой гаргаад **байнаа** даа, тэгэхэд чинь тэр хүн чинь шахдаг, их бүдүүн хоолой гаргаж уншдаг тийм л хүн байсан юм. Их хүнгэнэсэн, исгэрсэн дуу гаргаад. Хурал удирдана, хурал эхлээд ороод суухаар зэрэг тэр хүн чинь эхлээд уншиж гаргана.

Асуулт:-Гол шүтээн нь ямар бурхан байсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй, хүн амьтан гишгэчихсэн, зөндөө л том том баримал **бурханууд** байсан юм.

Асуулт:-Хийдийг нь модоор барьсан байсан уу?

Хариулт:-Модоор.

Асуулт:-Чулуугаар барьсан биш үү?

Хариулт:-Үгүй, дандаа модоор. Ерөөсөө манай аав ээжийн аав ээж ярьж байсан юм. Дээр үед чинь манай энд чинь орос, буриад нар их байсан юм гэнэ лээ. Тэгэхээр Орхон, Сэлэнгийн чинь мөсөөр өвлийн цагт дандаа хар мод, дүнз, том том модыг чинь мөсөөр чирч морьтой чарган дээр дандаа тийм ердийн хөсгөөр аваачиж байсан.

Асуулт:- Тэр Амарбаясгалангийн хийд бий шүү дээ, тэрний ард Бүрэнгийн нуруу гэж байдаг билүү, тэр нуруун дээрээс наашаа харахад орой нь цухуйж байхаар маягтай бүтээсэн гэж ярьдаг юм билээ, тэр үнэн үү?

Хариулт:-**Эрдэнэ вангийн** хүрээнээс ганжир нь харагдаж байна гэж үү?

Асуулт:-Тийм, харагдахаар бүтээсэн юм, цаанаасаа зохион байгуулалттай хийсэн, бүтээсэн гэж.

Хариулт:-Мэдэхгүй, тэрнийг би худлаа хэлж мэдэхгүй...

Асуулт:-**Амарбаясгалант** хийд чинь Бүрэнгийн нурууны яг урд талд байгаа.

Хариулт:-Урагшаа, нэлээн урагшаа. Рашаантын том уулаас урагшаа.

Асуулт:-**Эрдэнэ вангийн** хүрээн дээр цам **Майдар** гардаг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Гаралгүй **яхав**.Цам **Майдар** их сайхан цам **Майдар** гарна.

Асуулт:-Хэдэн сард гардаг байсан юм бол?

Хариулт:-Зуны эхэн сарын шинийн 8-нд гардаг байл уу, хаашаа билээ? Тийм л байсан даг. Цам бол. Майдар бол чухам хэдэн сард хавар юмуу, явж байхыг бодоход зуны сар шиг санагдаад байдаг, энүүгээр чинь дандаа **бирваазтай**, дандаа л морьтой, морин тэрэгтэй, үхэр тэрэгтэй л явж байсан юм даг, **бирваазаар** гараад л.

Эрдэнэ вангийн хүрээ бол баян гэж ярьдаг юм билээ. Олон шүтээнтэй, тэрний баг, өмсгөл, лам нарын хэрэглэл, цам **Майдарын** хэрэглэл гэдэг чинь замгүй их юм байсан шүү дээ. Тэр чинь ер нь тэр сайхан их юмыг хойш нь л зөөсөн байх.

Асуулт:-Орос руу юу?

Хариулт:-Тийм. Тэр том том бурхан тахилыг чинь тэр үед айхтар ширүүн байсан юм даа,

Асуулт:-**Эрдэнэ вангийн** хүрээг хэдэн онд ямар нэртэй хүн үүсгэсэн юм бол?

Хариулт:-Мэдэхгүй

Асуулт:-Сүүлд хэзээ устаж үгүй болов?

Хариулт:-Тэр үймээний үеэр л. Будлиан гарлаа шүү дээ.

Асуулт:-Барилга **байшингий** нь яасан юм бол?

Хариулт:-Гадагш нь зөөгөөд... харин жинхэнэ гол дуган нь үлдээд байсан гэсэн, сүүлдээ юу болсон бүү мэд.

Асуулт:-Эрдэнэ вангийн хүрээ урагшаа Төвдийн хийдүүдтэй холбоотой байсан юмуу?

Хариулт:-Холбоотой л байсан байх....

Асуулт:-**Эрдэнэ вангийн** хүрээний лам нар ямар уул овоогоо тахидаг байсан юм бол?

Хариулт:-**Эрдэнэ вангийн** хүрээний чинь хойд талд ингэсэн том уул байгаа биз дээ. Хоёр талаараа хошуу **урагшаагаа** шаасан. Баруун хошууны цаад талд нь дээр үеийн ноёд, тамгын газар байсан юм. Тэр хойд талын уулыг чинь юу гэж ярьдаг билээ, **тэрэн** дээр чинь бүх хүүхдүүд хавар гарч л тахидаг байсан юм.

Асуулт:-Лам хүүхдүүд үү?

Хариулт:-Тийм. Тэр дацанд байгаа бүх хүүхдүүд. Бас л тэндээ барилдаад, наадам хийдэг байсан тиймэрхүү л байдаг байсан.

Асуулт:-Та тэнд **уралдаггүй** байсан юмуу?

Хариулт:-Үгүй, тэнд очиж уралдаагүй. **Эрдэнэ ван** чухам өөрөө хаана юугаа ч хийж байсан юм мэдэхгүй.